

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАРТАЙ ХОЛБООТОЙ ТОГТООЛ

ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022 оны X сар хэрэгжилт

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын тогтоол							
1	1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4.				НБХ

			төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
11	17	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33	XIII.1. . Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл	Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн дэмжлэгийн багийн 5 гишүүнд Ганцаарчилсан сургалтын талаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Нийт 5 багш ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллаж байна. Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 100% байгаа нь багш бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллах арга зүйд бүрэн суралцсан, хүүхдийг хөгжүүлэх,ахиц амжилтыг илрүүлэхэд ахиц гарган ажиллаж байгаа нь сайн үр дүнд хүрч байна.	100		НБХ

			мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах.				
13	21	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоо”-д хамруулах зорилгоор “Эрүүл мэндийг дэмжих зардлын төсөв”-ийг төсөвт тусгагдсантай холбоотойгоор аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан 19 сургуулиас 17 сургууль буюу 89% нь хамрагдсан ба нийт 570 багш, ажилчид хамрагдсан байна. Мөн 22 цэцэрлэг 100% хамрагдсан бөгөөд нийт 311 багш, ажилчид хамрагдаад байна.	100		НБХ ЭМГ

			Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.				
ЗГ-ын албан даалгавар							
17	28	Нийслэлийн цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх, 2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай 2022-07-28 Дугаар 2022_7	4. Монгол Улсын болон орон нутгийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 80-с дээш хувийн гүйцэтгэлтэй боловсролын байгууллагын барилга байгууламжийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор ашиглалтад бүрэн оруулах арга хэмжээ авах, гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг саадгүй олгох, шаардлагатай тохиолдолд магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан нэмэлт зардлыг 2023 оны төсвийн төсөлд тусгах арга	Төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхан-овоо суманд баригдаж буй 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, спорт зал 95 орчим хувийн гүйцэтгэлтэй 2022 оны 12 сард ашиглалтанд өгөхөөр дотор засал болон тохижилтын ажил, Гурвансайхан суманд баригдаж байгаа 100 хүүхдийн дотуур байрны барилга 95 хувийн гүйцэтгэлтэй 2022 оны 11 сард багтаан ашиглалтанд өгөхөөр ажиллаж байна.	70		НБХ ХБТХОХ

		хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;				
29		5. Боловсролын сургалтын байгууллагад хийгдэж байгаа их болон урсгал засварын ажлыг 2022 оны 8 дугаар сарын 25-ны дотор дуусгаж, хичээлийн жил эхлэх бэлтгэл ажлыг хангуулах, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийн 1, 2 дугаар ээлжийн хөрөнгө оруулалтын ажлыг гэрээний хугацаанд багтаан хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийн 1 дугаар ээлжийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэдалай болон Цагаандэлгэр сумдад хийгдэж байгаа ариун цэврийн байгууламж 90-с дээш хувийн гүйцэтгэлтэй, БЕГ-н хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн болон зөвлөх инженер, аймгийн ГХБХБГазрын мэргэжилтэн нарын хамтарсан ажлын хэсэг урьдчилсан комисс хийж зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.	70		НБХ ХБТХОХ
Өөрийн үнэлгээний дундаж				85 хувь		

ТАЙЛАН ХЯНАСАН:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН АЛБАНЫ ДАРГА

Л.ОЮУНБАЯР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Ц.ОТГОНЖАРГАЛ